

まんがでわかる


安全衛生と 労災防止の基本



Монгол хэл
モンゴル語版

Комикоор танилцах

Хөдөлмөрийн аюулгүй байдал, ослоос урдчилан сэргийлэх үндэс







Шаардлага байгаа шүү, Тошиаки.

Аан..., за

Хөдөлмөрийн осол бол ажил мэргэжлийн төрлөөс үл хамааран бүхий л хүмүүст тохиолдох магадлалтай.

Хамгаас чухал бие махбодио хамгаалахад суралцах хэрэгтэй.

Яг тийм шүү!



Анги уу даа?!

За, эхлээ.

За



Эхлээд яавал хөдөлмөрийн ослоос урьдчилан сэргийлэх боломжтойг бодож үзье.

Хөдөлмөрийн осол, албан хэллэгээр "Ажлын байран дахь хөдөлмөрийн осол"

Хөдөлмөр эрхлэхэд хамгийн чухал нь эрүүл бөгөөд аюулгүй ажиллах явдал юм.

Үүнийг нэг үгээр юу гэж хэлдгийг мэдэх үү?



Эрүүл, аюулгүй ажиллах ...

Аан, "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй" гэдэг шүү дээ.



Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

Мундаг! Хэцүү үгийг сайн мэдэж байна шүү.

Мэдээж шүү дээ, энгийнээр бол "Аюулгүй байдал, эрүүл ахуй" гэж хэлсэн ч болно.

Тийм ээ.

Ажилчид эрүүл,
аюулгүй ажиллах
боломжтой ажлын
байр —

Хөөх, компани нь
ажилчдын аюулгүй байдал,
эрүүл мэндийг хамгаалах
үүрэгтэй байдаг юм байна.



Ажил олгогч аюулгүй
байдал, эрүүл ахуйг
хангасан ажлын
байр бий болгох
шаардлагатай.

Мэдээж хөдөлмөр
эрхлэгч ч бас маш
сайн анхааралтай
байх хэрэгтэй.

Сая Тошиаки "Хөдөлмөрийн
осол гээд тусгайлан хичээл
хийх шаардлага байдаг юм уу?"
гэсэн байх аа?

Гэхдээ, хөдөлмөрийн
ослын шалтгаан
үнэндээ ямар ч ажлын
байранд нуугдаж
байдаг.

Тэгээд, бидний эргэн
тойронд ч маш их осол
үүсэж байдаг нь бодит
байдал.



Тийм гэж үү?

Аанхан. Зөвхөн
хөнгөн бэртэл
өвчин төдийгүй,

хүнд гэмтэл,
цаашлаад үхэлд
хүргэсэн ослын
бодит түүх ч бий.

Аймар юм аа.

Энэ графикийг хардаа.

"Шууд үхэлд хүргэсэн осол",
"4 болон түүнээс дээш өдрийн эмчилгээ шаардлагатай, үхэлд шууд бусаар хүргэсэн хүнд гэмтэл"-ийг нэгтгэсэн зүйл юм.

Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам "2018 оны Хөдөлмөрийн осол үүссэн байдал" (2018 он)

Үхэлд хүргэсэн осол **909** хүн

1 Нурж унах, Өндрөөс унах
256 хүн

2 Зам гээврийн осол
175 хүн

3 Хавчигдсан, татагдсан
113 хүн

4 болон түүнээс дээш өдрийн эмчилгээ шаардлагатай, үхэлд шууд бусаар хүргэсэн хүнд гэмтэл **127,329** хүн

1 Явганаас бэртэх
31,833 хүн

2 Нурж унах, Өндрөөс унах
21,221 хүн

3 Хөдөлгөөний инерци, эвгүй хөдөлгөөнөөс үүдэлтэй
16,958 хүн

Айн! Жилд 909 хүн амь насаа алдсан юм уу?

"Нурж унах, Өндрөөс унах", "Явганаас бэртэх" тохиолдол маш их юм аа.

Хамгийн эхэнд хэлсэн—

Эвхдэг шатан дээрээс тэнцвэр алдах,

Ачаа зөөж байхдаа шатнаас хий гишгэх

Нойтон шалан дээр хальтрах

Аль аль нь бидний өдөр тутамд үүсэж болохуйц явдлууд байгаа биз?

Тийм байна шүү. Надад ч бас ойр нэг юм байна аа.

Ослын шалтгаан нь ажлын төрөл, байрнаас хамаараад янз бүр байдаг.

Гэхдээ, маш сайн анхааралтай байснаар урьдчилан сэргийлж чадсан тохиолдлууд ч бас бий.

Хөдөлмөрийн осолд өртөж байгаа хүмүүс нь над шиг шинэ ажилчид байдаг уу?

Тийм шүү, гэхдээ—

Ахмад ажилчид хүртэл хайхрамжгүйгээсээ алдаа гаргах нь байдаг.



Явал хөдөлмөрийн ослоос урьдчилан сэргийлэх боломжтой вэ?



Ажлын байрнаас хамаараад нөхцөл байдал янз бүр байдаг учраас, нэг үгээр хэлэхэд хэцүү л дээ...

Ажлын талбарын дүрмийг дагаж мөрдөх

Хөдөлмөрийн багаж хэрэгслийг зөв ашиглах


"Нэг л биш байна" гэж санагдвал даруй удирдлагадаа мэдэгдэх

Нилээд үндсэн ойлголтууд байна шүү.

Үндсэн ойлголтууд боловч маш чухал юм шүү.

Дүрэм дагаж мөрдөхийг тээршааж ч магад л даа

Гэхдээ, дүрэм зөрчсөнөөс болж үүссэн хөдөлмөрийн осол маш их байдаг.



Дүрмэнд утга учир бий.

Эцэст нь хэлэхэд, өөрөө өөрийгөө хамгаалах нь хамгийн чухал.

Тийм ч учраас хөдөлмөрийн ослын талаар суралцаасай гэж хүсэж байна.


За, ойлголоо.



За!

Хөдөлмөрийн ослоос урьдчилан сэргийлэх аргын талаар илүү бодитоор сурахын тулд...

ガー...



3

2

1

おあっ...



Хөдөлмөрийн ослоос урьдчилан сэргийлэх үндэс

Хөдөлмөрийн ослын талаар хураангуйлж нэгтгэсэн бичлэг үзэцгээе.



Эрүүл мэндийн үзлэг

Өөрийн эрүүл мэндийн байдлыг мэдэж авах нь маш чухал.




Эрүүл мэндийн үзлэгт ямар төрөл байдаг вэ?

Ажилд орохын өмнөх болон жилд нэг удаа хийгдэх эрүүл мэндийн үзлэг байдаг.



Японд ажилчид жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт хамрагдаад байдаг тийм ээ.

Тиймээ. Ажил олгогч нь ажилчдаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах үүрэгтэй ийм улс ховор шүү.




Ажилчдынхаа эрүүл мэндийг хамгаалдаг сайхан тогтолцоо юм аа.

Эрүүл мэндийн үзлэгтээ заавал хамрагдацгаая.

Явганаас бэртэх


Явганаас унах нь хүнд гэмтэл, бэртлийн суурь болдог!



Эхлээд бидний эргэн тойронд байгаа хальгарч унах эрсдлийг шалгаж үзэцгээе.




1 Корридор, шат, гарах хаалган дээр ямар нэг юм орхичихсон байгаа юм биш биз?




2 Шалан дээрх ус, шавхайг сайтар цэвэрлэсэн үү?



3 Ажлын гутал чинь таарч байна уу?



4 Халаасандаа гараа хийгээд алхаад байгаа юм биш биз?



5 Сунгалтын болон бусад дасгал хийж байна уу?



Хөдөлмөрийн ослоос хамгийн их нь явганаас унах юм.



Гэмтэл авсан хүмүүсийн 60% нь 1 сараас дээш хугацаагаар өвчний чөлөө авдаг юм уу?

Ялангуяа ахмад настанд их тохиолддог гэсэн байх аа.


Хүнд бэртэл авахгүйн тулд, унахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай.



Гол анхаарах зүйл Жишээ нь ийм арга байж болно


4S-Эмх(Seiri), Цэгц(Seiton), Цэвэрлэгээ(Seiso), Цэвэр(Seiketsu)

- Хүн явдаг газар юм орхихгүй байх
- Шалны гадаргуун бохирдлыг цэвэрлэх
- Шалны гадаргуун овгор товгор, догол зэргийг арилгах



Явганаас бэртэхгүй байх аргачлал

- Ажлын цагийг тулгахгүй байх
- Хальтрамтгай газраар аажуу явах
- Хөл доорх гадаргуу ил харагдахгүй газраар явахгүй байх



Ажилд тохирсон гутал өмсөж, хальтиргаатай газрыг бусдад анхааруулах нь үр дүнтэй.



あなたの職場は大丈夫？	
転倒の危険をチェックして改善しよう	
チェック項目	
1	通路、階段、出口に物を設置していませんか？
2	床のホコリや水、油、脂粉などは拭き取らず、その場所を踏み回っていますか？
3	安全に掃除できるように十分な明るさ（照明）が確保されていますか？
4	転倒を予防するための教育を行っていますか？
5	作業服は、作業現場に合った機能性があり、かつちょうど良いサイズのものを選んでいませんか？
6	ヒールハット履きを使用して、転倒しやすい種類の危険なマップを作ったり、着用していますか？
7	指定のある場所や機材のやり取り場所などに注意を促す標識を付けていますか？
8	ポケットに手を入れたまま歩くことを禁じていますか？
9	ストリートシューズや靴擦れ防止のための滑靴を履いていませんか？



Аюултай газрыг мэдэж авах нь чухал юм байна шүү дээ.

Тэмдэг тавьсан байгаа газрыг онцлон анхаараарай.


Өндрөөс унах



Налуу болон эвхдэг шат ашиглан өндөрт ажиллах нь ихээхэн аюултай.

Налуу шат ашиглах үед үүсэж болох осол, авах арга хэмжээ

Налуу шатан дээр тэнцвэрээ алдах.




Гол анхаарах зүйл

Илүү аюулгүй ажиллах арга бий эсэхийг судалж үзэцгээе




Хойш савж унах




Гол анхаарах зүйл

Сайтар бэхлэх эсвэл хэн нэгнээр түшүүлэх хэрэгтэй.




Налуу шатаар өгсөж, уруудах үед хөл гар хальтрах.



Гол анхаарах зүйл

Хальгардаггүй гутал, бээлий ашиглах хэрэгтэй.




Аюулгүй хэрэглээний гол анхаарах зүйл

Шатыг хэвтээ шугамд 75°-ын налуутайгаар байрлуулж, үзүүр нь 60см-аас дээш илүү гарсан эсэхийг шалгах хэрэгтэй.




Эвхдэг шат ашиглах үед үүсэж болох осол, авах арга хэмжээ

Эвхдэг шатны орой дээр тэнцвэрээ алдах




Гол анхаарах зүйл

Орой дээр гарахгүй байх.




Эвхдэг шатан дээр мордож, тэнцвэрээ алдах



Гол анхаарах зүйл

Эвхдэг шатан дээр мордохгүй байх



Ачаа авч гараад, тэнцвэрээ алдах



Гол анхаарах зүйл

Ачаатай шат руу өгсөж, уруудахгүй байх



Аюулгүй хэрэглээний гол анхаарах зүйл

Эвхдэг шатны дээрээсээ 2 дахь гишгүүрээс доош ашиглаж, биеийн тогтворгүй байрлал авахаас зайлсхийх хэрэгтэй.



Толгойгоо хамгаалахын тулд, үргэлж хамгаалалтын малгай өмсөж байх нь дээр шүү.



Аюулгүй хэрэглээний 4 гол анхаарах зүйл

1. Эрүүний оосрыг сайтар уях
2. Хазайлгахгүйгээр тэгш өмсөх
3. Эвдэрсэн малгай ашиглахгүй байх
4. Ашиглалтын хугацааг баримтлах

Ялангуяа эрүүний оосрыг сайтар уяарай.



Нурууны ӨВЧИН



Нурууны өвчин нь хурдан архагшдаг тул өнөөдрөөс анхаарах хэрэгтэй.



Хүнд юм зөөхдөө тавцант тэрэг болон хайрцаг сав ашиглах нь илүү дээр юм байна шүү дээ.



Өдөр тутамдаа сунгалтын дасгал хийж урьдчилан сэргийлэх нь ч бас чухал.

Тавцант тэрэг, хайрцаг сав ашиглах боломжгүй тохиолдолд зөв арга хэрэглэцгээ.

Өргөх байрлал

БУРУУ
Өвдгөө нугалалгүйгээр нуруундаа ачаалал өгөх

Гол анхаарах зүйл

Энэ байрлалаас, өвдгөө сунган хөл, өвдөгний хүчээр өргөнө

Ачааны байрлал

БУРУУ
Биеэсээ ачааг холдуулах

Гол анхаарах зүйл

Аль болох биедээ ачааг ойртуулж хүндийн төвийг багасгах хэрэгтэй.

Биед зөв арга

БУРУУ
Биеийн зөвхөн дээд хэсгээр ачааг өргөх

Гол анхаарах зүйл

Зөвхөн нуруугаараа эргэлгүй, бүтэн биеэрээ эргэх.

Лавлах материал: Барилгын салбарын хөдөлмөрийн ослоос урьдчилан сэргийлэх холбоо "Таныг хамгаалах гол зүйл: Нурууны өвчнөөс урьдчилан сэргийлэх аргачлалын эмхтгэл"

4S



4S гэдэг бол бидэнд хамгийн ойр газраас эхлэн аюулгүй, ажиллахад хялбар ажлын байрыг бий болгох зорилготой үйл ажиллагаа юм.

Хэрэггүй зүйлсээс салцгаая.

Эмх (Seiri)

Хэрэгтэй зүйлсээ цэгцэлж хадгалцгаая

Цэгц (Seiton)

Ажлын байраа цэвэрлэгээ

Цэвэрлэгээ (Seiso)

Ажлын байраа ч, ажиллаж байгаа хүн нь ч цэвэр сайхан байдлаа хадгалцгаая.

Цэвэр (Seiketsu)

4S-ыг нэвтрүүлсэн ажлын байранд бол бүгдээрээ эрч хүчтэй, сайн ажиллаж чадах нь ээ.

Би ч гэсэн өөрийн эргэн тойрноосоо эхлэн янзалж үзнээ.

Лавлах материал: Хөдөлмөрийн ослоос урьдчилан сэргийлэх төв хороо "4S-ын үндсэн ойлголт"

Наранд цохиулах*

※ Агаарын өндөр хэм, чийгшлийн улмаас толгой өвдөх зэрэг шинж тэмдэг илэрч тавгүйтэхийг хэлнэ.



Японы халуун зун, наранд цохиулахгүй байх арга танилцуулъя.


Гол анхаарах зүйл 1

Шингэн, давс ойр ойрхон нөхөх



Гол анхаарах зүйл 2

Сэрүүн газар түр амрах



Гол анхаарах зүйл 3

"Нэг л биш байна" гэж санагдвал шууд мэдэгдэх



Бас, согтууруулах ундаанаас татгалзаж, өглөөний хоолоо сайтар идэх чухал шүү дээ.



WBGT нь 28 хэмээс дээш болонгуут наранд цохиулсан өвчтөн ихэсдэг гэнэ лээ.

Урдчилан сэргийлсэн ч наранд цохиулчихсан бол яаралтай анхны тусламж үзүүлэх хэрэгтэй.

■ Анхны тусламж 1 Сэрүүхэн газар аваачих



■ Анхны тусламж 2 Хувцсыг нь нимгэлэх



■ Анхны тусламж 3 Спорт усаар шингэн нөхөх



■ Анхны тусламж 4 Биеийг нь сэрүүцүүлэх



Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хамгаалалтын багаж хэрэгсэл



Хамгаалалтын малгай

Толгой дээрээс юм унах, өндрөөс унах үед толгойг хамгаална.

Аюулгүй хэрэглээний 4 гол анхаарах зүйл

1. Эрүүний оосрыг сайтар уях
2. Хазайлгахгүйгээр тэгш өмсөх
3. Эвдэрсэн малгай ашиглахгүй байх
4. Ашиглалтын хугацааг баримтлах

Ялангуяа эрүүний оосрыг сайтар уяарай.



Хамгаалалтын нүдний шил

Нүд рүү тоосонцор, хэлтэрхий орохоос хамгаална.



Дуу тусгаарлагч




Чихийг дуу чимээнээс хамгаалахын тулд хэрэглэнэ. Дуу чимээний хэмжээнээс хамаараад өөр өөр багаж хэрэгсэл ашиглана.

Амьсгал хамгааллын хэрэгсэл

Агаарын тоос, тоосонцор шороо болон хий зэргээр амьсгалахаас хамгаална.

Хийн маск

Хорт хийгээр амьсгалахаас хамгаална.



Тоосны макс

Агаар дахь тоос шороогоор амьсгалахаас хамгаална.




Нэг удаагийн болон даавуун масканд ийм үр дүн байхгүй.




Бээлий

Түлэгдэх болон зүсэгдэх, ачаа зөөх үед гулгахаас хамгаална. Даавуун, резинэн гээд, хэрэглээнээс хамааран сонгож ашиглана.



Химийн хамгаалалтын бээлий

Химийн бодисоос арьсаа хамгаалахад хэрэглэдэг бээлий.




Аюулгүй гутал




Хүнд юм хөл дээр унах, хадаас зэрэг үзүүртэй зүйл гишгэх, төхөөрөмжид хөлөө хавчуулахаас хөлийг хамгаална.

Бэхэлгээ

Өндрөөс унахаас урьдчилан сэргийлэхэд хэрэглэдэг.



Өмссөн байх ёстой цаг үе, газарт зөв хэрэглэхгүй бол хамгаалалтын багаж хэрэгсэл байхын утга байхгүй



Гол анхаарах зүйл 1

Тус тусын ажлын талбайн орчин нөхцөл, ашиглах материал болон ажилдаа тохирсон хамгаалалтын багаж хэрэгслийг сонгох хэрэгтэй.



Гол анхаарах зүйл 2


Нүүр, гар, хөл зэрэг өөрийн биеийн хэмжээнд тохирсон хамгаалалтын багаж хэрэгслийг сонгох хэрэгтэй.



Хэмжээ нь таарахгүй бол, шууд солиулж авах хэрэгтэй.

Гол анхаарах зүйл 3

Зөв өмсөж, зөв хэрэглэцгээе Бүх чадамжийг хангалттай харуулж чадахгүй шүү дээ.



Лавлах материал: Хөдөлмөрийн ослоос урьдчилан сэргийлэх төв хороо "Таныг хамгаалах аюулгүй байдал, эрүүл мэндийн хамгаалалтын багаж хэрэгслийн хөтөч - Үйлчилгээний салбарт ажиллаж байгаа хүний төлөө." Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам "Хөдөлмөрийн эрүүл ахуйн хамгааллын багаж хэрэгсэл (Амьсгалын хамгааллын хэрэгсэл, хамгаалалтын бээлий, хамгаалалтын нүдний шил)"

Аюулгүйн тэмдэглэгээ

Аюулгүйн тэмдэглэгээ 5 төрөл байдаг. Энд гол төлөөллүүдийг танилцуулъя.

Аюулгүйн тэмдэглэгээ нь, ажлын байранд далд байгаа аюул осол болон чухал мэдээллийг "Нүдэнд харагдахуйц" болгосноор ажилчдыг аюулгүй ажиллах боломжоор хангадаг.

Хориглох тэмдэглэгээ (prohibition sign)



Зааварчлах тэмдэглэгээ (mandatory action sign)



Анхааруулах, сэрэмжлүүлэх тэмдэглэгээ (warning sign)



Аюулгүй байдлын тэмдэглэгээ (safe condition sign)



Гал түймрийн тэмдэглэгээ (fire equipment sign)



Аюулгүй байдлын тэмдэглэгээ янз бүрийн төрөл байдаг байх нь ээ.

"Нүдэнд харагдахуйц" болгосноор хэн ч бай амархан аюултай юу аюулгүй юу гэдгийг мэдэх юм байна.

Ажлын байрнаас хамаараад янз бүрийн аюулгүй тэмдэглэгээ ашиглагддаг.


Өөрийн ажлын байранд ямар тэмдэглэгээ байдгийг нэг удаа шалгаад үзээрэй

За.


Ажилдаа явах


Ажилдаа явах зам зуур ч аюул бий шүү.

Мэдээжийн зүйл боловч, бид бүгдээрээ замын хөдөлгөөний дүрмээ баримталвал осол гарцаагүй багасна.



Хэрвээ гэмтсэн, өвдсөн хүн байвал, эрт арга хэмжээ авах нь хамгийн чухал.





Комикоор танилцах Хөдөлмөрийн аюулгүй байдал, ослоос урдчилан сэргийлэх үндэс

2020 оны 3 сарын хэвлэл

Эрхлэн гаргасан: Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Төлөвлөсөн: Mizuho Information & Research Institute, Inc.

Хянан тохиолдуулсан: Хөдөлмөрийн аюулгүй байдал,
эрүүл ахуйн сургалтын материал бэлтгэх комисс

Хөдөлмөрийн ослоос урьдчилан сэргийлэх төв нийгэмлэг

Боловсруулсан: Sideranch Inc.



症状・病状説明のための 指さしシート

Зовиур, өвчний шинж тэмдгийг тайлбарлах зураг заах хуудас

このシートの利用方法 | Энэ хуудсыг ашиглах заавар

例 | Жишээ


病状と、その程度を示して伝えましょう。

Зовиур, түүний хэр хэмжээг зураг дээр зааж дамжуулаарай.



頭が痛い

Толгой өвдөж байна



我慢できる

Тэвчиж чадна




かなりつらい

Нилээд хэцүү байна



頭が痛い

Толгой өвдөж байна




のどが痛い

Хоолой өвдөж байна

せきがでる

Ханиалгаж байна



熱がある

Халуурч байна



腰が痛い

Нуруу өвдөж байна


足がしびれる

Хөл бадайрч жирвэгнээд байна



めまいがする

Толгой эргэж байна



膝が痛い

Өвдөг өвдөж байна

曲げられない

Нугалж чадахгүй



おなか(胃)が痛い

Гэдэс(ходоод) өвдөж байна

下痢

Гүйлгэж байна




かぶれた

Арьс улайж хавдсан

発疹がでた

Тууралт гарсан




目が痛い

Нүд өвдөж байна

目がかゆい

Нүд загатнаж байна

怪我をした | Гэмтсэн



転倒した

Бүдэрч унасан

落ちた

Ойчсон




刺さった

Хатгуулсан


やけどした

Түлэгдсэн




切った

Зүссэн




ぶつかった

Мөргөлдсөн



我慢できる

Тэвчиж чадна



かなりつらい

Нилээд хэцүү байна



Тус материалын талаарх лавлагаа

Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн
стандартын хороо, Аюулгүй байдал, эрүүл ахуйн газар,
Аюулгүй байдлын хэлтэс